



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/85

Булган сум

┌ Эрх шилжүүлэх тухай ┐

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсан сумдын Засаг даргын Тамгын газарт олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулж, гэрээ байгуулан, хүлээн авахыг хавсралтад заагдсан сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Т.Баттулга/-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Батцогт/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323019023

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 сарын 18-ны
 өдрийн А/Б дүгээр захирамжийн 1-р хавсралт

№	Төсөл арга хэмжээний нэрс	Нийт төсөвт өртөг	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумдын дарга
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт						
1	Бугат сумын ЗДТГ-ын барилгын засвар	300,000.0	300,000.0	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Х.Ууганбаяр
2	Ахуйн үйлчилгээний барилгын засварын 2 дахь шатны ажил (Гурванбулаг сум)	200,000.0	200,000.0	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Б.Дэлгэр
НИЙТ ДҮН		500,000.0	500,000.0			